



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/125/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/224

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АСГАТ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.УРАНЧИМЭГ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

13.8 сая төгрөгийн зардлын Э баримтыг бүрэн бүрдүүлээгүй, нэр бүхий ажилтнуудад 4.1 сая төгрөгийн цалин, нэмэгдлийг илүү тооцож олгосон, 4.7 сая төгрөгийн хэмнэгдсэн зардлыг зориулалт бус зарцуулан, холбогдох газрын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, 2.5 сая төгрөгийн зарцуулалтын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн зэрэг зөрчлүүд нь ( Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5,13.6, 20.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт зэрэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй) байна.

01302/171

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,176,044.61</b>	<b>17,417,682.01</b>
	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>27,176,044.61</b>	<b>17,417,682.01</b>
351	Түүхий эд материал	2,454,199.40	2,804,788.40
35110	Тусгай зориулалттай материал	2,313,239.40	2,804,788.40
3510	Эм боох материал	140,960.00	
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>24,721,845.21</b>	<b>14,612,893.61</b>
35410	Бичиг хэргийн материал	3,329,570.00	1,047,297.00
35420	Аж ахуйн материал	9,506,622.00	5,216,362.00
35440	Түлш, шатах тослох материал	20,000.60	
35450	Хүнсний материал	11,865,652.61	8,349,234.61
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,094,009.96</b>	<b>119,775,794.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>101,094,009.96</b>	<b>119,775,794.88</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>95,044,009.96</b>	<b>114,055,794.88</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,778,900.00	89,778,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,299,180.04	-4,795,495.08
39205	Машин тоног төхөөрөмж	14,951,752.00	33,659,652.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,452,752.00	-12,152,552.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,105,890.00	9,605,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,105,890.00	-7,105,890.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,544,000.00	4,544,000.00
39217	Ном фонд	521,290.00	521,290.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,050,000.00</b>	<b>5,720,000.00</b>
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга		-330,000.00
39303+393	Бусад биет бус хөрөнгө	4,400,000.00	4,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>128,270,054.57</b>	<b>137,193,476.89</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>128,270,054.57</b>	<b>137,193,476.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>128,270,054.57</b>	<b>137,193,476.89</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	48,148,231.80	48,148,231.80
51101	Өмч: -Төрийн өмч	48,148,231.80	48,148,231.80
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-490,651.23</b>	<b>8,432,771.89</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-490,651.23	-490,651.23
51220	Тайлант үеийн үр дүн		8,923,422.32

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,612,474.00	80,612,474.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>128,270,054.57</b>	<b>137,193,476.89</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>229,397,400.00</b>	<b>241,459,949.00</b>	<b>0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,699,000.00</b>	<b>13,696,549.00</b>	<b>0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,699,000.00</b>	<b>13,696,549.00</b>	<b>0</b>
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,699,000.00	13,696,549.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,699,000.00	13,696,549.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>224,698,400.00</b>	<b>227,763,400.00</b>	<b>0</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,386,400.00</b>	<b>25,504,800.00</b>	<b>0</b>
ДТ(132001)	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	<b>19,386,400.00</b>	<b>25,504,800.00</b>	
ДТ(132006)	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг /		400,000.00	
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>205,312,000.00</b>	<b>202,258,600.00</b>	<b>0</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,312,000.00	202,258,600.00	0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>228,739,903.18</b>	<b>232,536,526.68</b>	<b>8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>228,739,903.18</b>	<b>232,536,526.68</b>	<b>8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>216,413,903.18</b>	<b>227,788,782.03</b>	<b>3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>129,239,831.00</b>	<b>140,232,391.35</b>	<b>5</b>
210101	Цалин	129,239,831.00	140,232,391.35	5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,958,406.00</b>	<b>19,315,451.00</b>	<b>0</b>
210201	Тэтгэврийн даатгал шимтгэл	17,365,358.00	13,618,813.00	
210202	Тэтгэмжийн даатгал шимтгэл	1,398,263.00	1,424,158.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал шимтгэл	1,118,607.00	1,139,329.00	
210204	Ажилгүйдлийн даатгал шимтгэл	279,652.00	284,832.00	
210205	Эрүүл мэндийн даатгал хураамж	2,796,526.00	2,848,319.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,799,062.40	24,962,817.00	
210301	Гэрэл, цахилгаан зардал	250,746.00	1,049,617.00	
210302	Түлш, халаалт зардал	23,647,000.40	23,413,200.00	
210303	Цэвэр, бохир ус зардал	901,316.00	500,000.00	

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,367,186.17</b>	<b>13,139,489.60</b>
210401	Бичиг хэргийн материал	1,534,700.00	4,584,773.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,841,886.17	1,930,396.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	560,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,430,600.00	4,555,320.00
210407	Аж ахуйн материалхудалдан авах зардал	0.00	1,369,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,572,742.00</b>	<b>23,806,318.00</b>
210501	Эм	2,446,600.00	2,686,060.00
210502	Хоол	20,513,642.00	20,504,118.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	612,500.00	616,140.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>523,100.00</b>	<b>541,600.00</b>
210604	Урсгал засвар	523,100.00	541,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>450,000.00</b>	<b>850,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	450,000.00	850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>690,000.00</b>	<b>390,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		390,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,813,575.61</b>	<b>4,550,515.08</b>
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага зардал		2,024,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,813,575.61	2,526,115.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,326,000.00</b>	<b>4,747,744.65</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>4,747,744.65</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	4,747,744.65
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	12,326,000.00	
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,326,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>657,496.82</b>	<b>8,923,422.32</b>
<b>VI</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>657,496.82</b>	<b>8,923,422.32</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	43,748,231.80	5,516,099.20	23,812,368.70	73,076,699.70

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,748,231.80	5,516,099.20	23,812,368.70	73,076,699.70
7	Тайлант үеийн үр дүн (Цэвэр ашиг, алдагдал)	0.00	0.00	-2,475,432.35	-2,475,432.35
8	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	-490,651.23	128,270,054.57
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	-490,651.23	128,270,054.57
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	-490,651.23	128,270,054.57
16	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,923,422.32	8,923,422.23
17	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	8,923,422.32	137,193,476.89

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	224,698,400.00	227,763,400.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	224,698,400.00	227,763,400.00
3	Улсын төвлөрсөн төсвөөс	205,312,000.00	201,858,600.00
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт	205,312,000.00	25,504,800.00
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,386,400.00	25,904,800.00
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,386,400.00	25,504,800.00
7	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		400,000.00
8	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	223,048,400.00	219,760,500.00
9	УРСГАЛ ЗАРДАЛ	223,048,400.00	219,760,500.00
10	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,722,399.60	215,012,755.35
11	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,673,999.60	140,346,291.35
12	Үндсэн цалин	95,284,105.00	98,521,933.55
13	Нэмэгдэл	33,388,313.15	32,642,253.80
14	Унаа хоолны хөнгөлөлт	350,000.00	1,098,746.00
15	Урамшуулал	9,651,581.45	8,083,358.00
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,095,900.00	19,201,551.00
17	Тэтгэврийн даатгал	13,437,900.00	13,513,900.00
18	Тэтгэмжийн даатгал	1,414,500.00	1,422,500.00
19	ҮОМШӨ-ний даатгал	1,131,600.00	1,138,000.00

20	Ажилгүйдлийн даатгал	282,900.00	284,500.00
21	Эрүүл мэндийн даатгал	2,829,000.00	2,842,651.00
22	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,386,400.00</b>	<b>24,962,817.00</b>
23	Гэрэл, цахилгаан	492,750.00	1,049,617.00
24	Түлш, халаалт	18,668,600.00	23,413,200.00
25	Цэвэр, бохир ус	225,050.00	500,000.00
26	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,434,600.00</b>	<b>5,606,696.00</b>
27	Бичиг хэрэг	1,257,900.00	1,257,700.00
28	Тээвэр, шатахуун	2,738,600.00	1,910,396.00
29	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	700,000.00
30	Ном, хэвлэл	56,200.00	56,700.00
31	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,681,900.00	1,681,900.00
32	<b>Нормативт зардал</b>	<b>23,023,100.00</b>	<b>20,101,100.00</b>
33	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргсэл	2,545,100.00	2,545,100.00
34	Хоол, хүнс	19,910,000.00	16,987,700.00
35	Нормын хувцас, зөөлөн эдлэл	568,000.00	568,300.00
36	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>541,600.00</b>
37	Урсгал засвар		<b>541,600.00</b>
38	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>450,000.00</b>	<b>850,000.00</b>
39	Дотоод албан томилолт	450,000.00	850,000.00
40	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,741,000.00</b>	<b>390,200.00</b>
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,591,000.00	
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		390,200.00
43	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	
44	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,917,400.00</b>	<b>3,012,500.00</b>
45	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,917,400.00	3,012,500.00
46	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,326,000.40</b>	<b>4,747,744.65</b>
47	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,326,000.40</b>	<b>4,747,744.65</b>
48	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,326,000.40	4,747,744.65
49	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,650,000.00</b>	<b>8,002,900.00</b>
50	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,650,000.00</b>	<b>8,002,900.00</b>
51	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,650,000.00</b>	<b>8,002,900.00</b>
52	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,650,000.00</b>	<b>8,002,900.00</b>
53	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,000.00	8,002,900.00
54	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>227,175,900.00</b>	<b>223,015,655.35</b>	4,160,244.65
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>227,175,900.00</b>	<b>223,015,655.35</b>	4,160,244.65
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>227,175,900.00</b>	<b>223,015,655.35</b>	4,160,244.65
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>142,251,800.00</b>	<b>140,346,291.35</b>	1,905,508.65
5	Үндсэн цалин	96,258,400.00	98,521,933.55	-2,263,533.55
6	Нэмэгдэл	35,249,100.00	32,642,253.80	2,606,846.20
7	Унаа хоолны хөнгөлөлт	500,000.00	1,098,746.00	-598,746.00
8	Урамшуулал	10,244,300.00	8,083,358.00	2,160,942.00
9	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,203,900.00</b>	<b>19,201,551.00</b>	2,349.00
10	Тэтгэврийн даатгал	13,513,900.00	13,513,900.00	0.00
11	Тэтгэмжийн даатгал	1,422,500.00	1,422,500.00	0.00
12	ҮОМШӨ-ний даатгал	1,138,000.00	1,138,000.00	0.00
13	Ажилгүйдлийн даатгал	284,500.00	284,500.00	0.00
14	Эрүүл мэндийн даатгал	2,845,000.00	2,842,651.00	2,349.00
15	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,963,200.00</b>	<b>24,962,817.00</b>	383.00
16	Гэрэл, цахилгаан	1,050,000.00	1,049,617.00	383.00
17	Түлш, халаалт	23,413,200.00	23,413,200.00	0.00
18	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	0.00
19	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,435,000.00</b>	<b>5,606,696.00</b>	828,304.00
20	Бичиг хэрэг	1,257,700.00	1,257,700.00	0.00
21	Тээвэр, шатахуун	2,738,600.00	1,910,396.00	828,204.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	700,000.00	0.00
23	Ном хэвлэл	56,800.00	56,700.00	100.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,681,900.00	1,681,900.00	0.00
25	<b>Нормативт зардал</b>	<b>20,101,100.00</b>	<b>20,101,100.00</b>	0.00
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,545,100.00	2,545,100.00	0.00
27	Хоол, хүнс	16,987,700.00	16,987,700.00	0.00
28	Цэвэр, бохир ус	568,300.00	568,300.00	0.00
29	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>541,600.00</b>	<b>541,600.00</b>	0.00
30	Урсгал засвар	541,600.00	541,600.00	0.00
31	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>852,400.00</b>	<b>850,000.00</b>	2,400.00
32	Дотоод албан томилолт	852,400.00	850,000.00	2,400.00

33	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,811,500.00</b>	<b>390,200.00</b>	1,421,300.00
34	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,811,500.00	390,200.00	1,421,300.00
35	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,015,400.00</b>	<b>11,015,400.00</b>	0.00
36	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,015,400.00	11,015,400.00	0.00
37	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>227,175,900.00</b>	<b>227,763,400.00</b>	-587,500.00
38	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>201,271,100.00</b>	<b>201,858,600.00</b>	-587,500.00
39	Улсын төсвөөс санхүүжих			0.00
40	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	201,271,100.00	<b>201,858,600.00</b>	-587,500.00
41	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	25,904,800.00	25,904,800.00	0.00
42	Орон нутгийн төсвөөс	25,904,800.00	25,904,800.00	0.00
44	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	
45	Төсвийн байгууллага	1.00	1.00	
46	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>	
47	Удирдах ажилтан	1.00	1.00	
48	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	
49	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	
50	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>110.00</b>	<b>110.00</b>	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Асгат сумын хүүхдийн цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн амьдралд хэрэгтэй чадварыг хөгжүүлсэн эрүүл аюулгүй амьд орчинг бүрдүүлэх, ухаалаг, хамтач, цэгцтэй, уйгагүй оролдлоготой, бүтээлч, эрүүл чийрэг, баяр баясгалантай иргэн төлөвших суурийг тавьж, суралцах хөгжихөд дэмжлэг үзүүлэх” зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 223.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	27,176.0	17,417.7	-9,758.3
Үндсэн хөрөнгө	101,094.0	119,775.8	18,681.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>128,270.0</b>	<b>137,193.5</b>	<b>8,923.5</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	128,270.0	137,193.5	8,923.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>128,270.0</b>	<b>137,193.5</b>	<b>8,923.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 9,758.3 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,681.8 мянган төгрөгөөр өссөн 21,207.9 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,923.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 227,175.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 227,175.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 201,858.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,904.8 мянган төгрөгийн, нийт 227,763.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 223,015.7 мянган төгрөгийг зарцуулан, 4,747.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл хөтлөлтөд тавих тавих дотоод хяналт хангалтгүй, хэмнэгдсэн зардлыг зориулалт бус зарцуулсан, холбогдох газрын

шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн зэрэг зөрчлүүдийг онцлон авч үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Ажилтнуудад цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулаагүй, худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, эд хариуцагчтай тооцоо бодож хэвшээгүй, хэмнэгдсэн зардлыг зориулалт бус зарцуулан, холбогдох газрын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 14 мэдээллийг байршуулан, доорх 8 мэдээллийг байршуулаагүй байна.

- ✓ Улирал бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- ✓ 2020 оны санхүүгийн тайлан
- ✓ 2020 оны аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- ✓ 8,002.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтын мэдээлэл
- ✓ 106,997.4 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хөрөнгийн тооллогыг чанартай хийх, эд хариуцагчтай тооцоо бодож хэвших гэн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нягтлан бодогчид зардлыг бүртгэхдээ бараа материалын болон өглөгийн дансаар дамжуулах, эд хариуцагчтай тооцоо бодож хэвших, эд хөрөнгийн тооллогод хяналт тавих, эд хариуцагчид бараа материалын тайланг сар бүр бүрэн гаргаж байх хугацаатай үүргүүдийг өгч биелэлтийг тооцох, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 165,074.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 25,285.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,309.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 133,480.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

##### **4.1 Залруулсан алдаа:**

Мөнгөн гүйлгээний тайланд 6,989.9 мянган төгрөгийн, өглөгийн тодруулгад 18,295.1 мянган төгрөгийн, нийт 25,285.0 мянган залруулга хийгдсэн.

Төлбөрийн актаас 2,987.8 мянган төгрөгийг аудитын хугацаанд барагдуулсан.

##### **4.2 Төлбөрийн акт :**

###### **1.1. Илрүүлэлт:**

- ✓ *Нэр бүхий ажилтнуудад 1,051.0 мянган төгрөгийн тэтгэмж, 3,092.5 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл, ээлжийн амралтын олговрыг илүү тооцоолж олгосон;*
- ✓ *2,165.8 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлэн, цэцэрлэгийн мөнгөн хөрөнгийг дутагдуулсан;*

###### **1.2. Шийдвэрлэлт:**

- ✓ *Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3, 4.2.3.7 дахь заалтуудыг үндэслэн илүү тооцож олгосон цалин хөлс, дутагдуулсан мөнгөн хөрөнгийг нөхөн төлүүлэхээр 6,309.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.*

##### **4.3 Албан шаардлага**

###### **1.1. Илрүүлэлт:**

- ✓ *Гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр усны зардлын хэмнэлтээс 4,664.6 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулан, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн;*
- ✓ *13,815.5 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй;*
- ✓ *Өмнөх оны аудитаар өгөөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, тайлант онд шилэн дансны цахим мэдээллийн санд 115,003.0 мянган төгрөгийн 8 төрлийн мэдээллийг мэдээлээгүй, алдаа зөрчлүүдийг давтан гаргасан;*

###### **1.2. Шийдвэрлэлт:**

- ✓ *Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6, 4.2.1.10 дахь заалтуудыг үндэслэн 133,480.3 мянган зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх үүргийг албан шаардлагаар хүргүүлээ.*

##### **4.4 Зөвлөмж өгөгдөөгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

##### **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Асгат сумын цэцэрлэг	5	165,074.6	3	25,285.0	1	6,309.3	1	133,480.3		